

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Нийслэлийн Төр, захиргааны авто бааз УТҮГ нь Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай хууль, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад холбогдох хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газраас төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгдсэн тайланд өгсөн аудитын зөвлөмж, дүгнэлтээр албан шаардлага ирүүлсний дагуу гаргасан зөрчлийг арилгах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг бүтцийн нэгжүүд төлөвлөгөө гарган батлуулж, биелэлтийг ханган ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдэж үйлчлэл нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлсэнтэй холбогдуулан Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дотоод журмыг Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ гэх нэршилтэй шинэчлэн батлуулахаар төслийг боловсруулан Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/58 дугаар тушаалаар хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг батлуулан, хэрэгжилтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөн ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан хөдөлмөрийн гэрээний загварыг шинэчлэх гэрээний төслийг боловсруулж байгууллагын даргын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар батлуулж ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг байгуулсан.

Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, журмыг хэрэгжүүлж, байгууллагын үндсэн чиг үүрэг, зорилтыг ханган биелүүлэх, төсөв зохиох, санхүүгийн эх үүсвэрийг хуримтлуулах, хуваарилан зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд санхүүгийн үйл ажиллагааг явуулах, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/995 дугаар захирамжийн дагуу байгууллагын бүтэц орон тооны зохион байгуулалтыг нийт 105 ажилтан, албан хаагчтайгаар шинэчлэн батлуулсан. Бүтэц, орон тоо, нэршил өөрчлөгдсөн бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн. Иймд 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах судалгааны тайлан”-г боловсруулсан.

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулахад дараах зүйлсийг харгалзсан. Үүнд:

-НЗД-ын 2021 оны А/995 дугаар захирамжаар батлагдсан байгууллагын бүтэц, орон тоо,

-Албан тушаалын ангилал,


-Зэрэглэл,

-Ажлын байрны шинжилгээ,

- Албан тушаалын тодорхойлолт боловсруулах мэдээлэл цуглуулах асуулга,
- Бусад холбогдох мэдээлэлд үндэслэн боловсруулсан.

Нийслэлийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 03 тоот албан бичгийн хүрээнд улирал тутамд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийн ажиллаж байна. I улирлын ариутгалыг 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр байгууллагын оффис болон паркуудад хийлгэсэн.

Нийслэлийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 07 тоот албан бичгийн түр зөвлөмжийн дагуу Коронавируст халдвар (ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, халдвар илэрсэн үед авах арга хэмжээний тухай түр зөвлөмжийг ажилтан, албан хаагчдад танилцуулан, хэрэгжилтийг ханган ажиллах талаар заавар зөвлөмжийг хүргэсэн.





Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 1102-03/172 тоот албан бичгийн дагуу “Эцэг эхийн зөвлөл”-ийн анхдугаар зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллахаар Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд хүүхдэд ээлтэй байгууллага байх тухай заалт оруулсан.

Нийслэлийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 14 тоот албан бичгийн Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, ажилтан, албан хаагчдаа цахимаар болон зайнаас ажиллуулах арга хэмжээ авч ажиллуулах албан даалгаврын дагуу хуваарь гарган газрын даргын тушаалаар батлуулан ажилласан.


Нийслэлийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны хурлын тэмдэглэлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу бага насны хүүхэдтэй 0-5 насны эх, өрх толгойлсон эцэг, эхийг 1 сарын хугацаанд цахимаар ажиллуулах, халдварын эрсдэлээс хамгаалах зохицуулалтыг авч цахимаар ажиллах хуваарь боловсруулан, газрын даргын тушаалаар батлуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/562 санал ирүүлэх тухай албан бичгийн дагуу байгууллагын өмнө тулгамдаж буй “Парк шинэчлэл хийх тухай” асуудлын саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 04/577 тоот санал ирүүлэх тухай албан бичгийн дагуу 2022 оны “Хотын иргэний жил” аяны төлөвлөгөө боловсруулан хугацаанд нь хүргүүлсэн.

Нийслэлийн Онцгой комиссын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн №3 хурлын тэмдэглэл “Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-д заасныг

баримтлан ажиллах журмыг ажилтан, албан хаагчдад танилцуулан мэдээллийн самбарт байршуулсан.



Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 03/1064 тоот албан бичгийн Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 04/1185 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 2022 онд хэлэлцүүлэхээр төлөвлөж буй асуудлуудын талаар яаралтай албан бичгийн дагуу “Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрэмд өөрчлөлт оруулах тухай” саналыг хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/1181 Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогод хамрагдах тухай 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/1181 албан тоот ирсний дагуу Газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/23 тоот тушаалаар батлагдсан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын хэсэг байгуулагдан журмын дагуу үзлэг тооллогын ажлын бэлэн байдлыг ханган сайн үнэлгээтэй ажилласан.

Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах Корона вирус (Ковид-19)-ийн халдвараас сэргийлэх дархлаажуулалтын вакцинд хамрагдсан судалгааг гаргаж эрүүл мэндийн эсрэг заалттай 11 албан хаагч, тун хоорондын хугацаа болоогүй 10 албан хаагч, 1,2 дугаар тунд 101 ажилтан бүрэн хамрагдсан. 3 дугаар тунд өссөн дүнгээр хийт 71 албан хаагч хамрагдсан.

Хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх “Нэгдүгээрт шалга” арга хэмжээг зохион байгуулсан тухай ажлын тайланг гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/995 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтад Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийг заасан “Суудлын автомашин хэрэглэх тухай” Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/480, “Тариф шинэчлэн батлах тухай” 2008 оны 409, “Суудлын автомашин ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоол зэргийг үндэслэн 33 байгууллага руу 36 “Автомашинаар үйлчлэх гэрээ”-ний төслийг явуулснаас 2022 оны 06 дугаар сарын байдлаар 33 гэрээ батлагдаж ирсэн.


“Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ” нь 2015 оноос хойш шинэчлэгдээгүй байсан. Уг гэрээнд байгууллагын лого тусгагдсан загварын эх хувьтай. Байгууллагын лого шинэчлэгдэхэд гэрээний загварыг шинэчлээгүй байсан. Мөн Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдэж гэрээний үндэслэлүүд өөрчлөгдсөн тул “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-г шинэчлэх төслийг боловсруулан шинэчлэгдсэн эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээгээр 2022 оны 01 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ нь ажил олгогч, ажилтан нарын үндсэн гэрээ болох Хөдөлмөрийн гэрээний дагалдах гэрээ тул загварыг тушаалаар батлаагүй. Уг гэрээг зөвхөн үйлчилгээний жолооч нартай байгуулдаг байсан бол 2022 оноос эхлэн тенхикч-няравтай байгуулж эхэлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдан 05 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх болсонтой холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/789 тоот захирамж гарч Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж нийслэлийн харьяа төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Мөн хэмнэлтийн тухай хуультай холбоотойгоор төрийн байгууллагын автомашинуудыг “Дуудлагын автомашинаар үйлчлэх журам”-ыг удирдлага болгож хэрэглэгч байгууллагуудтай байгуулдаг “Автомашинаар үйлчлэх гэрээ”-г “Дуудлагын автомашинаар үйлчлэх гэрээ” болгон өөрчлөх гэрээний төслийг боловруулан хянуулах шатандаа явж байна. Захирамжид дурьдсанаар байгууллагын үйлчилгээний тарифыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тогтоохоор заасан. Шийдвэр гараагүй, чиглэл ирээгүй тул гэрээний төсөл бүрэн батлагдаагүй.



Монголын Жүдо бөхийн холбооны 2022 оны календарчилсан төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн А/600 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн дагуу хэрэгжилтийг ханган Парис-2024 зуны олимпын наадмын албан ёсны оноо олгох “Улаанбаатар их дуулга-2022” жүдо бөхийн олон улсын тэмцээнд зочны үйлчилгээнд явах тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн, цэвэрлэгээ үйлчилгээний бэлэн байдал, жолооч нарын харилцааны соёл, хувийн соёлыг хангуулан хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилга өгч нийт 13 тээврийн хэрэгслээр зочноо дээдлэх, байгууллагын соёл, багийн ажиллагаа, хамтын хүчин чармайлтаар аваар осолгүй, бүрэн үйлчилсэн.



Сургалт: Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ны 03/683 сургалтад хамруулах тухай албан бичгийн дагуу Ub.legal.mn цахим хуудасны шинэчлэл, засварын ажил хийгдэж байгаатай холбогдуулан хийгдсэн сургалтад 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр байгууллагын хүний нөөцийн ажилтан О.Алтаннавч, эрх зүйн асуудал хариуцсан ажилтан Б.Солонго нар Хангарьд ордны Их танхимд зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан.



Авлигын эсрэг үндэсний чуулган 2022 оны 02 дугаар сард чуулж түүнээс гарсан зөвлөмжийн дагуу байгууллагын ажилтан, албан хаагчдад “Авлигын эсрэг гэмт хэрэг” гэх нэртэй мэдээллийг байгууллагын ажилтан, албан хаагчдын мэдээллийн цахим хаягт байршуулсан.



Ажилтан, албан хаагчдад сахилгын шийтгэлийн хор уршгийг таниулах, ямар тохиолдолд хийсэн санаатай болон болгоомжгүй үйлдэл нь сахилгын зөрчил болох талаар мэдээллийг багтаасан “Сахилгын шийтгэл, түүний үр дагавар” сэдэвт мэдээллийг боловсруулж байгууллагын ажилтан, албан хаагчдын цахим хуудсанд байршуулан, паркуудаар танилцуулах сургалтыг эрх зүйн асуудал хариуцсан ажилтан Б.Солонго зохион байгуулсан.



Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ны 03/1288 тоот албан бичгийн дагуу Нийслэл “RISE-Academy” сургалтыг 03 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд тус сургалтын удирдамж хуваарийг байгууллагын удирдлагад танилцуулж мэдээлэл технологи, архив бичиг хэргийн ажилтан Ц.Дэлгэрмаа хамрагдсан.

Нийслэлийн Хуулийн хэлтсээс 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан UB.legal тогтоол шийдвэр хөтлөлтийн сургалтад Эрх зүйн ажилтан Б.Солонго, хүний нөөцийн ажилтан О.Алтаннавч нар хамрагдсан.

Төрийн албаны зөвлөлөөс 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан Манлайлал сэдэвт сургалтад захиргааны нийт 10 албан хаагчид цахимаар оролцож хамрагдсан.



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
АЛБАНЫ ЗӨВЛӨЛ



“7:4:10” вэбинар сургалт



А.ДАВААСҮРЭН

Гүйцэтгэх захирал,
Ахлах сургагч багш
Дэйл Карнеги Трейнинг Монгол

“МАНЛАЙЛЛЫН ХЭВ МАЯГ, ХАНДЛАГАА ТОДОРХОЙЛОХ НЬ”

Нийслэлийн нэгдсэн удирдлагын цахим erp.ulaanbaatar.mn программ, өргөдөл, гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх сэдэвт сургалтад 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр захиргааны албан хаагчдыг хамруулан ажилласан.



Гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр “Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” зурган мэдээллийг байгууллагын ажилтан, албан хаагчдын цахим хуудас, групп чатанд байршуулж, тээврийн хэрэгслийн торгуулиа төлөх боломжуудыг талаар сургалтыг эрх зүйн асуудал хариуцсан ажилтан Б.Солонго зохион байгуулсан.



Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулсан Авлигын эсрэг “Шударга ёсыг эрхэмлэе” зөвлөгөөнд 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр байгууллагын дарга Э.Болор-Эрдэнэ, захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Н.Батцэцэг, тээвэр, зохицуулалтын хэлтсийн дарга Ч.Энхсайхан, санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Үүрцайх нар оролцсон.



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төв, Азийн сангийн Хотын засаглалыг сайжруулах төслийн хамтран зохион байгуулж буй “Нийслэл-110” менторшип хөтөлбөр 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн албан бичгийн хэрэгжилтийг хангуулан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын дунд зохион байгуулагдсан менторшип хөтөлбөрт хүсэлт илгээсэн 168 албан хаагчдаас 80 хүн шалгарсаны 1 менти болж хөтөлбөрт

оролцон өөрийгөө хөгжүүлэн, ур чадвараа нэмэгдүүлэхээр эрх зүйн асуудал хариуцсан ажилтан Б.Солонго шалгарч амжилттай 1 дүгээр хөтөлбөрөө амжилттай дүүргэсэн.



Монгол Улсын төрийн албаны зөвлөл, Монголын бүтээмжийн төвийн хамтарсан “Төрийн байгууллагын бүтээмж” сэдэвт сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр цахимаар зохион байгуулахад нийт захиргааны албан хаагчид хамрагдсан.



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
АЛБАНЫ ЗӨВЛӨЛ



МОНГОЛЫН
БҮТЭЭМЖИЙН
ТӨВ



Н. БАТБИЛЭГ

Дэд захирал
Ахлах эксперт
МОНГОЛЫН БҮТЭЭМЖИЙН ТӨВ

“7:4:10” вэбинар сургалт ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЭМЖ


Нийслэлийн засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг нэг мөр ойлгох, сурталчлан таниулах сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Тус сургалтад Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Н.Батцэцэг, хүний нөөцийн ажилтан О.Алтаннавч, эрх зүйн асуудал хариуцсан ажилтан Б.Солонго нар хамрагдсан.



Албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвийн Ёс зүйн сургалтад Ёс зүйн зөвлөлийн гишүүн Б.Үүрцайх, О.Алтаннавч, Ч.Энхсайхан, Ц.Дэлгэрмаа Б.Мөнх-Эрдэнэ болон диспетчер механик А.Баярсүх нарыг сургалтад хамруулсан. Байгууллагын албан хаагчдад ёс зүйтэй холбоотой

өргөдөл гомдлыг хэрхэн хаана, хэнд өгөх талаар сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр цахимаар зохион байгуулсан.

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийн талаар, байгууллагын албан хаагчийн ёс зүйтэй холбогдолтой гомдол мэдээллийг хаана, хэнд хандан мэдээлэх талаарх мэдээ, мэдээллийг (animaker ашиглан) байгууллагын албан хаагчдад цахим хуудас болон групп чатанд байршуулж танилцуулсан.



Захиргаа, хүний нөөцийн чиглэлээр: Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/995 дугаар захирамжаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу байгууллагын бүтэц нь 105 орон тоотойгоор ажиллаж байна.

Байгууллагын бүтэц орон тооны хувьд:

Дарга -1

Захиргаа, хүний нөөцийн хэлтэс - 9


Санхүү, төлөвлөлтийн хэлтэс – 3

Тээвэр, зохицуулалтын хэлтэс – 92 нийт 105 ажилтан, албан хаагчтай.

2022 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 35, хүний нөөцийн холбогдолтой 105 тушаал, шийдвэр гарч холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн онд байгууллагын хэмжээнд 22 албан хаагч шинээр томилогдож, 22 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн байна.

Боловсон хүчний холбогдолтой Б тушаал нь:

- Ажилтан албан хаагчдын ээлжийн амралт-7
- Цалингүй чөлөө-9
- Үндсэн ажилтнаар томилох-14
- Сахилгын шийтгэл-12
- Урамшуулал олгох тухай-18



Байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлттэй холбоотой дүрэм, журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулж, албан тушаалын тодорхойлолтын нэршил өөрчлөх тушаалыг шинэчлэн боловсруулж, байгууллагын даргын тушаалаар батлан дагаж мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын 105 албан хаагчдын 18-50 насны “Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицер”, авто тээврийн бүртгэлийн тухай судалгаануудыг гарган Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны нийгмийн ажилтанд албан бичгээр 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлсэн.

**Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай
ажиллуулах албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх хөгжүүлэх,
нийгмийн баталгааг хангах талаар**

1. Ажилтан, албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөөг батлуулан ажилллаж байна.



2. Ажилчдын дэлгэрэнгүй судалгаа, өндөр настны судалгаа, байр орон сууцны нөхцөлийн, ажилтнуудын хүүхдийн, шагналын судалгааг тус тус гарган тусламж дэмжлэг шаардлагатай өргөдөл, гомдлыг хүлээн авч нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар шат дараатай арга хэмжээг аван ажиллаж байна.

3. Байгууллагын Биеийн тамир, спортын хамтлагийг шинэчлэн байгуулж Газрын даргын тушаалаар батлуулан, судалгаа гарган Биеийн тамирын спортын газарт мэйл хаягаар судалгааг хүргүүлсэн.


4. Эцэг эхийн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж Газрын даргаар батлуулан, байгууллагын дотоод хэм хэмжээнд хүүхдэд ээлтэй байгууллага байх, ажилтны хүүхдийг гадаадын олимпиад арга хэмжээнд оролцон шагнал авахад урамшуулах заалт оруулсан.

5. Байгууллагаас 2016-2021 онд ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхээр тогтоогдсон, байгууллагаас нөхөн олговор олгосон, буруутай албан тушаалтнаар хохирол нөхөн төлүүлсэн тухай судалгааг Нийслэлийн Дотоод аудитын газарт албан бичгээр хүргүүлэв. Тус хугацаанд асуудал гараагүй болно.


Нийт ажилтан албан хаагчид:



Мэргэжил, ур чадварын талаар:



	Эрэгтэй	Эмэгтэй
Бүрэн дунд боловсрол	23	0
Мэдээллээ оруулаагүй	18	4
Дипломын дээд боловсрол	9	5
Суурь боловсрол	11	1
Магистр эсвэл түүнтэй тэнцэх боловсрол	1	2
Техникийн эсвэл мэргэжлийн	16	1
Бакалавр эсвэл түүнтэй тэнцэх боловсрол	6	2
Нийт ажилтан	84	15



Нийгмийн баталгааг хангах чиглэлээр: Нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллагын дотоод журамд заасны дагуу шинээр мэндэлсэн хүүхдийн-4 ажилтанд цалинтай чөлөө, өндөр настны тэтгэвэрт гарсан-1 ажилтанд 1 удаагийн тэтгэмж нийт ажилтан албан хаагчдаас 4 хүний нийгмийн асуудлыг шийдвэрлэж тэтгэмж олгосон. Мөн Төрийн дээд одон медаль Алтангадас одонгоор шагнагдсан үйлчилгээний жолооч Х.Арилдий, Б.Намсрай, З.Батчулуун, С.Ганбат нарт

байгууллагын Дотоод хэм хэмжээнд заасны дагуу дурсгалын зүйл, өндөр насны тэтгэвэрт гарч буй диспетчер-механик Ж.Энхбаяр нарт дурсгалын зүйл гардуулж хүндэтгэл үзүүлэв.



Сар шинийн баярыг тохиолдуулан 2022 оны 2 дугаар сарын 3-наас 4-ний өдрүүдэд байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан нийт 37 ахмад настанд цагаан сарын гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлсэн.



Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор шинэ яармаг Хангарди ордонд 3 мкв талбай бүхий ажлын байрыг тохижуулан жолооч нарын амрах өрөөг шинээр гаргасан. Тус өрөөнд амарч суух зориулалттай сандал, ус буцалгагч, хоол халаах богино долгионы зуух, ширээ, мэдээ мэдээллийн самбар байршуулж тохижуулсан.



Байгууллагын дэргэдэх зөвлөл байгуулах талаар:

Байгууллагын дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны жилийн эцсийн тайланг гарган дүгнүүлж, 2022 оны төлөвлөгөөг гарган баталгаажуулан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралдаан хийж 01 болон 02 дугаар хурлын тэмдэглэл, дүгнэлтийг гарган баталгаажуулж холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан.

- Байгууллагын дэргэдэх Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам
- Байгууллагын нууцтай харилах журам боловсруулж батлуулсан. Журам нь байгууллагын нууцын тухай хууль, хувь хүний нууцын тухай хууль, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, эрх зүйн хэм хэмжээнээс бүрдэнэ.
- Эцэг эхийн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж, батлуулсан.
- Хөдөлмөрийн маргаан таслах комисс. Хөдөлмөрийн маргаан таслах комиссын бүрэлдэхүүнийг ажилчдын дунд 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр нээлттэй сонгон шалгаруулт зарлаж газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/13 дугаар тушаалаар баталсан.

Хүний нөөц бүрдүүлэлтийн талаар: Хүний нөөц бүрдүүлэлт дээр Шуурхай зар сонин, байгууллагын вэб цахим хуудаст ажлын зарыг байршуулж, Зангиа.мн сайт дээр шаардлагатай байгаа ажлын орон тооны зарыг зарлаж 26 ажил горилогчийн анкет авч хүний нөөцийн бүрдүүлэлт хийж, ярилцлагад оруулан, сонгон

шалгаруулалт хийж байна. Хүний нөөцийн ил тод байдлыг ханган мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Зангиа.мн <https://www.zangia.mn/> зарын сайт идэвхитэй ажил хайж буй ажлын байруудыг 30 хоногийн хугацаатай байршуулдаг. Идэвхитэй 3 ажлын байрны зар нийтлэхэд нийт 16 ажил горилогч материалаа ирүүлж ярилцлагад орсон байна.

#	Оруулсан	Зарын гарц	Нийтлсэн огноо	Дуусал огноо	Үсэн тоо	Сүүд үсэн огноо	Ирсэн CV	Үйлдэл
1	Атганаан	Нягтлан бодогч	2022/06/27 09:11	2022/07/27 23:59	1	2022/06/27 09:11	CV ирээгүй	Засах, Даруулах, Устгах
2	Атганаан	Диспетчер механик	2022/06/16 11:33	2022/07/16 23:59	43	2022/06/25 03:46	CV ирээгүй	Засах, Даруулах, Устгах
3	Атганаан	Үйлчилгээний жолооч	2022/06/16 10:38	2022/07/16 23:59	60	2022/06/26 20:58	7 CV	Засах, Даруулах, Устгах
4	Атганаан	Нярав	2022/06/07 18:26	2022/07/07 23:59	133	2022/06/25 14:39	9 CV	Засах, Даруулах, Устгах

Зангиа.мн зарын сайтад идэвхитэй хайж буй ажлын байруудыг 30 хоногийн хугацаатай байршуулсан. Хуучин 4 зарын архивт нийт 9 ажлын байрны 74 ажил горилогч нар анкетаа ирүүлсэн.




Зарлагдсан ажлын байрны зар 30 хоног сайт дээр байрладаг тул зарлагдаж байсан ажлын байрны зарууд нь зарын архивт хадгалагддаг. (Нийт 84 анкет)

Нийслэлийн Төр захиргааны авто бааз


Зарын архив

№	Оруулсан	Зарын гарим	Үсэгтэй	Нийлэгдсэн огноо	Дууссан огноо	Зарлагдсан өдөр	Сүүлд үсэгтэй огноо	Нэрсэн CV	Үйлдэл
1	Атганаев	Наран	81	2022/05/17 10:24	2022/06/18 23:59	31 хоног	2022/06/18 00:14	CV өргөжүүл	С Долом зарлах Устгах
2	Атганаев	Нэгтгэн бодогч	140	2022/05/18 19:33	2022/06/19 23:59	30 хоног	2022/06/18 00:44	10 CV	С Долом зарлах Устгах
3	Атганаев	Адаг хайтны инженер	46	2022/05/30 11:31	2022/06/13 13:31	14 хоног	2022/06/13 13:17	5 CV	С Долом зарлах Устгах
4	Атганаев	Адаг хайтны инженер	158	2022/04/18 10:08	2022/05/18 23:59	30 хоног	2022/05/18 11:32	5 CV	С Долом зарлах Устгах
5	Атганаев	Үйлчлэгчийн ажилчин	117	2022/05/11 10:15	2022/06/10 23:59	31 хоног	2022/06/10 14:10	8 CV	С Долом зарлах Устгах
6	Атганаев	Үйлчлэгчийн ажилчин	374	2022/04/11 19:28	2022/05/11 23:59	30 хоног	2022/05/12 00:46	37 CV	С Долом зарлах Устгах
7	Атганаев	Наран	190	2022/04/15 13:57	2022/05/15 23:59	30 хоног	2022/05/17 10:42	2 CV	С Долом зарлах Устгах
8	Атганаев	Наран	151	2022/04/25 18:09	2022/05/25 23:59	30 хоног	2022/05/25 07:08	7 CV	С Долом зарлах Устгах
9	Атганаев	Механик засварчин	158	2022/04/11 19:31	2022/05/11 23:59	30 хоног	2022/05/12 00:44	10 CV	С Долом зарлах Устгах


Шуурхай зар сонинд ажлын байрны зарыг 14 хоногт 2 удаагийн дугаарт захиалга өгч мэдээллээ оруулж зар байршуулсан.



Хүний нөөц бүрдүүлэлтийн судалгаанууд



Анкет ирүүлсэн ажил горилогчийн анализ




	Манаач	Нягтлан бодогч	Ашиглалтын инженер	Үйлчилгээний жолооч	Нярав	Механик засварчин
■ Анкет үзсэн хүний тоо	271	141	475	491	151	159
■ Анкет ирүүлсэн хүний тоо	2	10	5	45	7	10

АЖЛААС ЧӨЛӨӨЛӨГДСӨН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН СУДАЛГАА -23



Нийт үйлчилгээний жолооч-69





Боловсролын зэрэг	Эрэгтэй	Эмэгтэй
Бакалавр	23	2
Дипломын дээд боловсрол	7	5
Бага боловсрол	1	0
Техникийн эсвэл мэргэжлийн	19	1
Бүрэн дунд боловсрол	26	0
Магистр	4	2
Суурь боловсрол	20	3
Нийт ажилтан	100	13



Албан хаагчдын судалгаа (насны ангиллаар)

	Ажилтны тоо	Дундаж нас
Нийт ажилтан	100	100
Эрэгтэй ажилтан	87	42
Эмэгтэй ажилтан	13	41



Соёл олон нийтийн ажил:

1. Байгууллагын нийт 16 эмэгтэй ажилтанд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүлэн баярын арга хэмжээг зохион байгуулсан.

2. Эр цэргийн баярыг тохиолдуулан байгууллагын нийт 84 эрэгтэй ажилчиддаа хүндэтгэл үзүүлэн дурсгалын зүйлс гардуулж хүндэтгэл үзүүлсэн.



3. Баярлалаа аяныг 2022 оны 03 дугаар сарын 01-31-ний өдрийг дуустал 1 сарын хугацаанд зохион байгуулсан. Аяны зорилго нь байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ажилтан хоорондын хүндлэлийг бий болгох.



4.Зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны 101 жилийн ойг угтан Нийслэлийн Цэргийн штабаас зохион байгуулсан буудлагын тэмцээнд ХАБ инженер Г.Агваандондов 1 дүгээр байр эзэлж амжилттай оролцсон.



5.Байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд “Баярлалаа” аяныг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр, “Хотын иргэний жил” аяны хүрээнд байгалийн түүх дурсгалт газартай танилцах зорилгоор явган аялал, хоггүй аялал уриан дор Төв аймгийн Манзушир хийд рүү 2022 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр нийт ажилтнуудыг хамруулж, түүх дурсгалт газрыг үзэх, ойр орчмын хогийг түүсэн. Төрийн албаны зөвлөлөөс 2022 оныг Ёс зүйтэй төрийн албан хаагч жил болгон зарласантай холбогдуулан байгууллагын хамт олны дунд “Өглөөний цай” хөтөлбөрийг 3 паркад 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, “Авто баазын нэг өдөр” дурсамжийн самбарыг 2022 оны 06 дугаар сарын турш байршуулж ажилласан.






АВТО БААЗЫН НЭГ ӨДӨР



*Автомобилчин бүхэлд нь
Хүч, бэлтгэлтэй түүхчид
Төрийн тусламжтайгаар
Хүчтэй үйлчилж байна*

*Нийслэлд
Төрийн байр суурийг
Ахиуцаж, төрийн эрх
Төрийн тусламжтайгаар
Хүчтэй үйлчилж байна*


*Автомобилчин бүхэлд нь
Хүч, бэлтгэлтэй түүхчид
Төрийн тусламжтайгаар
Хүчтэй үйлчилж байна*



6. Онцгой байдлын Ерөнхий газрын шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвөөс улс орон даяар жил бүрийн гуравдугаар сарын дөрөв дэх долоо хоногийн пүрэв гаригийн 16 цагт орон даяар гамшиг, ослын дуут дохиог ажиллуулж, бэлтгэл сургуулилт хийхэд тус байгууллагын хамт олон цуглах цэгт цугларч бэлтгэл сургуулилтыг зохион байгуулсан.



7.Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулж ажилтан, албан хаагчид байгууллагын офисс, авто гарааш, авто засвар, авто угаалга, хашаан доторх болон ойр орчмын 50 метр орчмын нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх ажилд идэвхтэй оролцсон.



8.Нийслэлийн онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу 2021 оны 11 дүгээр сараас 2022 оны 03 дугаар сарыг дуустал хугацаанд Чингэлтэй дүүргийн 6, 19 дүгээр хороонд Коронавируст халдвар (Ковид-19) түүнээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөвлөгөөг өгч олон нийтэд ухуулга сурталчилгааг хүргэсэн. Таван толгой түлшийн нүүрс борлуулах 10 цэгүүдийн нөөц бүрдүүлэлт иргэдийн аюул осолгүй хэрэглээнд хяналт тавих чиглэлээр албан хаагчдыг өдөр тутмын хуваарьт оруулж хариуцлагатай жижүүрээр ажиллуулсан. Ажиллах хугацаанд таван толгой түлш ХХК нүүрс нь хог ихтэй бутрамтхай, шаталт удаан, тортог их, илч муу гэх гомдол гарсныг зохих холбогдох албан байгуулага, болон албан тушаалтанд мэдээллийг хүргэж ажилласан.



9. Байгууллагын гадна талбайд байрлах тамхины цэгийг өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан жолооч Г.Батхуяг, сантехникч Ц.Батсайхан нар гагнуур хийж шинэчилсэн.



10. "Илүүдэл жингүй-эртэч монгол" аяны хүрээнд дасгал хөдөлгөөн хийх хамт олны идэвх санаачлагыг дээшлүүлэх, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, урин цаг ирж байгаатай холбогдуулан эрүүл чийрэг, өв тэгш бие хаатай, илүүдэл жингүй, өөртөө итгэлтэй, дархлаа сайтай бие хүн болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор долоо хоногийн бямба гараг бүрийг спортын өдөр болгон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт байрлах спорт зааланд байгууллагын ажилтан, албан хаагчид спортоор тогтмол хичээллэж байна. Мөн байгууллагын фитнесийн өрөөг ашиглалтад оруулж ажилчдын эрүүл амьдрах хэв маягт дэмжлэг үзүүлэн, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжин, ажлын байрны орчныг сайжруулан ажиллаж байна.



11. "Улаанбаатар марафон-2022" Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор "Улаанбаатар Марафонд нэгдэцгээе" Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цом аялан явах хуваарийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТУГ-ын хамт олон Улаанбаатар музейн хамт олноос хүлээн авч, 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Монголын Хүүхдийн ордон НӨТБ-ын хамт олонд хүлээлгэн өгсөн.



12. "Улаанбаатар марафон-2022" олон улсын гүйлтэд байгууллага төлөөлөн нийт 6 ажилтан уг тэмцээнд оролцсоноос үйлчилгээний жолооч Т.Баатархүү, З.Сүхбат, Э.Мөнхдалай, Мэдээлэл технологи бичиг хэргийн ажилтан Ц.Дэлгэрмаа нар 5000 метрийн гүйлтийн уралдаанд амжилттай гүйж барианд орж батламж гардан авлаа.



13. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн "Бямба" гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласны дагуу байгууллагын нийт ажилтнуудыг бүрэн хамруулж мод тарих үндэсний өдөр бүх нийтээр мод, бут, сөөг, цэцэг тарих, цаашид арчлан хамгаалах, түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлэн сурталчилж "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус байгууллага нь 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Айцын ам гэх газар 90 суулгац суулгах ажлыг зохион байгуулсан.







14. Байгууллагын эцэг, эхийн зөвлөл, залуучуудын зөвлөлтэй хамтран 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Хүүхдийн эрхийг хамгаалах баярын арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 100 хүүхэд хамрагдсан бөгөөд 0-18 насны хүүхэдтэй 69 ажилтан албан хаагчын 136 хүүхдэд хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасны дагуу гарын бэлэг гардуулж, хүндэтгэлийн хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулсан.





15.Олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын нийт ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн дунд “МИНИЙ МЭДЭХ АВТО БААЗ-2022” сэдэвт гар зургийн уралдааныг зарлаж байна. Уг арга хэмжээний хүрээнд гар зургийн уралдааныг бага, дунд, ахлах анги гэсэн ангиллаар зохион байгуулж байр эзлүүлэн шалгарсан бүтээлүүдийг байр эзлүүлэн шагнаж урамшуулсан.



**Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй
холбоотой мэдээлэл**

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамж “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам” болон холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөн ажиллаж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем буюу www.erp.ulaanbaatar.mn цахим хуудсаар болон байгууллага дээрээ иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч ажилласан. Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-т 2022 оны эхний хагас жилийн байдлаар иргэн, хуулийн этгээдээс нийт 47 өргөдөл гомдлыг бүртгэн, өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Хүсэлт-51
 - ✓ Байгууллагын албан хаагчид-32
 - ✓ Иргэд-19
2. Гомдол-0 ирсэн байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа

Хүснэгт-1


Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Хоног	Цаг	Минут	Нийт өргөдөл, гомдол
	3	1	55	46

**2022 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг
өмнөх онтой харьцуулсан байдал**

2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд манай байгууллагад ирсэн нийт 47 өргөдөл, гомдлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-д бүртгэсэн байна.


Өнгөрөгч 2021 оны эхний хагас жилийн байдлаар 56 өргөдөл, гомдол хүлээн авч хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэсэн байна. 2021-2022 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эхний хагас жилийн байдлаар дараах графикаар харьцуулсан.

График-1



2022 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг (диаграмм-2) Захиргаа хүний нөөцийн хэлтэс 46, Санхүү, төлөвлөлтийн хэлтэс 1, байгууллагын хэмжээнд нийт 47 өргөдөл гомдлоос журмын дагуу хуулийн үндэслэлтэй 46 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, судалж байгаа өргөдөл 1 байна.

(Диаграмм 2)



2022 оны эхний хагас жилийн байдлаар хандалтаараа тэргүүлж буй асуудал нь иргэнээс ажилд орох хүсэлт 18 (39,13%), ажлаас чөлөөлөгдөх 13 (28.26%), цалинтай чөлөө хүсэх тухай 5 (10.87%), нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай 4 (8.70%), үйлчилгээний болон бусад салбарын албан хаагчийн ёс зүйн тухай 2 (4.35%), цалингүй чөлөө хүсэх тухай 1 (2.17%), цалин хөлсний тухай 1 (2.17%), ажилд шилжих, дэвшин ажиллах тухай 1 (2.17%), буцалтгүй тусламж хүсэх тухай 1 (2.17%) ирсэн байна.

Өргөдөл, гомдлын программд нийт 47 өргөдлийг бүртгэж, 46 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг журмын дагуу 5 хоногт 34 (73.91%), 10 хоногт 11 (23.91%), 15 хоногт (2.17%). 2022 оны байдлаар хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно. Өргөдөл, гомдлын индексээр (PCI) 0,87 буюу "B" үнэлгээтэй байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:



Байгууллагын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан өдөрт нь хүлээн авч, өргөдөл гомдлын нэгдсэн системд бүртгэж, удирдлагад өдөрт багтаан шилжүүлж, удирдлагын цохолттой ирсэн өргөдөл, гомдлыг тухайн албан хаагч өдөр нь хүлээн авч танилцан, явцын тэмдэглэлийг 10 хоног тутам хийж ажилласан.


2022 оны эхний хагас жилийн байдлаар өдөрт нь багтаан аваагүй, шийдвэрлэлтийн тэмдэглэл бичээгүй 5, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй байна. Өргөдөл гомдлын зөрчлийн тайланг өмнөх онтой харьцуулахад 12 нэгжээр буурсан үзүүлэлтэй байна.

2022 оны эхний хагас жилийн албан бичгийн шийдвэрлэлтийн тайлан

Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу байгууллагад хандаж ирсэн 143, явсан нийт 134 бичиг байна.

Байгууллагын хэмжээнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийтээр дагаж мөрдөх, цаг үеийн шинж чанартай болон байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой захирамжлалын баримт бичгүүд Засгийн газрын 1 тогтоол, Нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл 4, Нийслэлийн Засаг даргын захирамж 11, Зөвлөмж 2, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тушаал 1, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын тушаал 1 тус тус холбогдох заалтыг хэрэгжүүлэн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаж, хяналт тавин ажиллаж байна.

Явуулсан бичгийн шийдвэрлэлт нийт 134 үүнээс захиргаа хүний нөөцийн хэлтсийн 64 явуулсан үүнээс хариутай 2, хариугүй 62 бичиг, санхүү төлөвлөлтийн хэлтсээс нийт 51 бичиг явуулсан, тээвэр зохицуулалтын хэлтсээс нийт 19 бичиг явуулсан байна.





Нийслэлийн төр захиргааны авто бааз УТҮГ-ын
Баримт бичгийн эргэлтийн жагсаалт

№	Баримт бичгийн нэр	2021 оны эхний хагас жил	2022 оны эхний хагас жил
1	Тогтоол	3	1
2	Захирамж	14	11
3	Албан даалгавар, тушаал, зөвлөмж	4	6
4	Даргын А тушаал	35	35
5	Даргын Б тушаал	77	97
6	Ирсэн бичиг: нийт	117	139
	Хариутай бичиг	30	37
	Хариугүй бичиг	87	102
7	Төлөвлөгөө	6	6
8	Тайлан, биелэлт	6	6
9	Өргөдөл, гомдол	59	51
10	Явуулсан бичиг:		
	Нийт	73	134
	Тодорхойлолт	18	6
11	Хурлын тэмдэглэл нийт:	32	38
	Захиргааны	0	2
	Даргын зөвлөлийн	23	24
	Ур чадварын нэмэгдэл (шуурхай)	6	8
	Шагналын	3	4
12	Гэрээ:	84	203
	Автомашинаар үйлчлэх гэрээ	62	33
	Үр дүнгийн гэрээ	1	1
	Хөдөлмөрийн гэрээ	15	100
	Эд хөрөнгийн гэрээ хариуцлагын	10	69
13	Дүгнэлт	14	0

Албан хэрэг хөтлөлтийн eDoc.ub.gov.mn

2022 оны эхний хагас жилийн байдлаар Захиргаа хүний нөөцийн хэлтэст-76, Санхүү төлөвлөлтийн хэлтэст-26, Тээвэр зохицуулалтын хэлтэст-41 албан бичиг ирж, нийт 143 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин 92,74 хувийн шийдвэрлэлттэй ажиллаж байна.



Байгууллагаас явуулсан бичиг Захиргаа хүний нөөцийн хэлтэс-64, санхүү төлөвлөлтийн хэлтэс-51, Тээвэр зохицуулалтын хэлтэс-19 нийт 134 албан бичиг илгээсэн байна.



Байгууллагын хэмжээнд ирсэн хариутай бичгийн шийдвэрлэлт
(2022.01.01-2022.06.24)

Байгууллагын хэмжээнд ирсэн хариутай бичгийн шийдвэрлэлт 2022 оны 01 дүгээр сарын 01-с 06 дугаар сарын 24-нийг хүртэл нийт 37 хариутай албан бичиг ирсэн байна. Үүнээс: хугацаандаа шийдвэрлэсэн 30, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4, шийдвэрлээгүй 1, судалж байгаа 3 албан бичиг байна.

Архивын ажлын хүрээнд:

Нийслэлийн Архивын газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтан, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдэд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр зохион байгуулсан сургалтад Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Н.Батцэцэг, Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга Ч.Энхсайхан, ашиглалтын инженер Г.Агваандондов, хүний нөөцийн ажилтан О.Алтаннавч, нярав О.Одончимэг, Мэдээлэл технологи, архив бичиг хэргийн ажилтан Ц.Дэлгэрмаа нар Монголын хүүхдийн ордон, Нийслэлийн нутгийн захиргааны 5-р байранд зохион байгуулсан сургалтад хамрагдсан.



Байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/15 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Байгууллагын захиргааны албан хаагчдаас 2022 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг авч, 2022 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байгууллагын дэргэдэх БНШК-н хурлаар хэлэлцэж, батлуулсан.

2022 онд байгууллагын архивт 2021 оны ХХНЖ-ын дагуу захиргаа хүний нөөцийн хэлтэс, тээвэр зохицуулалтын хэлтсээс цаасан суурьтай 120 баримтыг нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авав.

2021 оны байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 61, боловсон хүчний холбогдолтой 195, нийт 256 захирамжлалын баримтыг Нийслэлийн архивын www.arch.ulaanbaatar.mn программд шивж, цахим нөхөн бүрдүүлэлт хийсэн.

2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Нийслэлийн Архивын газрын Төрийн архивын хэлтсийн цахим сангийн зааварлагч арга зүйч Ц.Энхцэцэгт захирамжлалын цахим баримтыг хүлээлгэж өгсөн.

The screenshot shows the 'Archive Doc' web application interface. The main content area displays a table of document records. The table has the following columns: Хөтлөгчийн код, Хөтлөгчийн дугаар, Хөтлөгчийн нэр, Дотоо дугаар, Үндэслэлийн нэгжийн дугаар, Баримтын төрөл, Цаасан баримтын дугаар, Хуудасны тоо, Хуудасны дугаар нэмэлт, Хуудасны дугаар дүрмэл, Баримтын төрөл, and Хөтлөгчийн нэр. The table contains several rows of data, including records with codes like 610, 615, and 616, and document numbers like 01, 02020, 021, 022, 023, 024, 025, 026, 027, 028, 029, 030, 031, 032, 033, 034, 035, 036, 037, 038, 039, 040, 041, 042, 043, 044, 045, 046, 047, 048, 049, 050, 051, 052, 053, 054, 055, 056, 057, 058, 059, 060, 061, 062, 063, 064, 065, 066, 067, 068, 069, 070, 071, 072, 073, 074, 075, 076, 077, 078, 079, 080, 081, 082, 083, 084, 085, 086, 087, 088, 089, 090, 091, 092, 093, 094, 095, 096, 097, 098, 099, 100.

Байгууллагын архивт 2021 оны архивын баримтуудыг хэлтэс нэгжээс нийт 150 баримтыг архив зүйн үүднээс баримтыг бүрдүүлж, хавтасжуулж авахаар ажиллаж байна. Нийслэл дэх төрийн аудитын шалгалт явагдаж байгаатай холбогдуулан санхүүгийн баримтыг шалгалтад дууссан даруй байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авахаар төлөвлөж байна.



Байгууллагын архивт хадгалагдаж байгаа байнга, түр, 70 жилийн баримтад нягтлан шалгалт хийж, нүүр бичилт буруу, баримтын хавтас гэмтсэн, 70 жилийн баримтад ажлаас чөлөөлсөн албан хаагчдын хувийн хэргийг архивын хавтсаар хавтаслаж, дугаарлаагүй байсан тул нийт 30 баримтыг архивын хавтсаар хавтаслаж, нүүр бичилт хийж дугаарласан. Мөн байнга хадгалах баримтуудыг хамгаалалтын хавтсаар хавтасжуулж, нэгдсэн бүртгэл үйлдэхээр ажиллаж байна.

Archive Doc

Цаасан суурь баримт **Хавтас** Нийт 3779

Excel-ээс оруулах | Нягтлан шалгалт /Буцаах/ | Шинэ | Сэргээх

Байнга хадгалах 70 жили хадгалах Тур хадгалах

2200 37 1609 1 3
 нийт тоо нийт хадгаламжийн нэгжийн тоо нийт баримтын хуудасны тоо хөмрөгийн тоо нийт дансны тоо

Он сонгох Бүх баганы утгаар... Q Хайх...

<input type="checkbox"/>	Хөмрөгийн код	Хөмрөгийн дугаар	Хөмрөгийн нэр	Дансны дугаар	Хадгаламжийн нэгжийн дугаар	Баримтын төрөл	Цаасан баримтын дугаар	Хуудасны тоо	Хуудасны дугаар эхлэсэн	Хуудасны дугаар дууссан	Баримтын тэргүү
<input type="checkbox"/>	Б10	0155	Нийслэлийн төр захиргааны Авто бааз	02	20212	Тушаал	A/61	4	126	129	Үр дүнгийн урамшуулал олгох тухай
<input type="checkbox"/>	Б10	0155	Нийслэлийн төр захиргааны Авто бааз	02	20211	Тушаал	A/03	15	21	35	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай
<input type="checkbox"/>	Б10	0155	Нийслэлийн төр захиргааны Авто бааз	02	20212	Тушаал	A/60	2	124	125	2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого явуулах комисс товчоох тухай

Хураах


Өнгөрсөн 2021 онд гарсан байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 61, боловсон хүчний холбогдолтой 195, нийт 256 захирамжлалын баримтыг Нийслэлийн архивын www.arch.ulaanbaatar.mn программд шивж, цахим нөхөн бүрдүүлэлт хийсэн.

Нийслэлийн Архивын газрын Төрийн архивын хэлтэст 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн №41 дүгээр актаар захирамжлалын цахим баримтыг сканнердсан мастер хувийн хамт хүлээлгэн өгсөн.

Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:

Байгууллагын цахим хуудаст шинэ мэдээ мэдээлэл оруулахад багтаамж дүүрсэн тул Супер ассист системс ХХК-тай байгууллагын цахим хуудсыг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэх гэрээ байгуулан цахим хуудсыг хөгжүүлж 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр актаар хүлээлцсэн болно.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай болон Шилэн дансны тухай хуулийн хүрээнд төрийн үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг "www.baaz.ub.gov.mn" цахим хуудсанд, байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт, гүйцэтгэл, тайлан мэдээ, Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ болон бусад дүрэм, журмууд даргын баталсан тушаал, нээлттэй ажлын байрны зар, санхүүгийн тайлан мэдээллийг байршуулахаар ажиллаж байна.



Эрх зүйн асуудал хариуцсан ажилтны болон Төв гараашийн диспетчер-механикийн компьютерын хурдыг сайжруулах үүднээс үндсэн 1ТВ хард дээр нэмэлтээр хурдны SSD хард (256gb) нэмж тавьж засвар үйлчилгээг хийлгэсэн.



Хоёр. Үндсэн үйл ажиллагааны талаар



Байгууллагын үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 184 дүгээр тогтоолын 2-т заасныг хэрэгжүүлэн нийслэлийн Засаг даргын захирамжийн хүрээнд автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллагатай ажил үйлчилгээний “Автомашинаар үйлчлэх гэрээ”-г 32 байгууллагын 70 хэрэглэгчидтэй байгуулан 79 автомашинаар үйлчилж, дуудлагын автомашиныг ажлын хоногт дунджаар 40 км-ээс хэтрүүлэхгүй хэрэглэж байх талаар хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2008 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн А/409 захирамжаар тогтоосон тарифын дагуу нийт хэрэглэгч байгууллагуудад 480,683 км зам явж үйлчилсэн байна.

Байгууллагын нийт хөдлөх бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/15 захирамжийн 1.4.3 дахь заалтын дагуу техникийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд төлөвлөгөө гарган, засвар үйлчилгээний графикийн дагуу засвар үйлчилгээг хийн, техникийн бүрэн бүтэн, бэлэн байдлыг ханган, 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр 17 автомашинуудад кузовын засвар, ТҮ-1: ТҮ-2 техник үйлчилгээг 45 автомашинд графикийн дагуу хийж, техникийн үзлэг Нийслэлийн Нийтийн тээврийн газрын шинээр байгуулагдсан Техникийн хяналтын үзлэгийн төвд механик инженер Г.Агваандондов нийт 78 автомашиныг оношилгоонд хамруулсан.

Автомашинуудад тавигдаж буй сэлбэгүүдэд хяналт тавьж, хувийн хэргийн бичилтийг сар бүр цаг тухайд нь, техникч-няравтай тулгалт хийн бичсэн. Мөн 2016 оноос хойших тээврийн хэрэгслийн хувийн хэргийн огт бичигдээгүй сэлбэг болон тос масло, дугуйн бүртгэлүүдийг нөхөн тэмдэглэл хөтлөхөөс гадна жолооч нартай хийх эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг хийсэн.

Авто баазын засвар үйлчилгээний 5D тэнхлэг тохиргоо болон автомат кропны тос солих төхөөрөмж, дугуй хийлэх азотын хий төхөөрөмжүүдийг ажиллуулахаар инженер, засварчдаа мэргэжлийн сургалтад хамруулж засварын газраа бүрэн ашиглалтад оруулсан.



Үйлчилгээний соёл, чанар, стандартыг ханган ажиллах, диспетчер механикийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хуваарийн дагуу ажлын байрны шалгалтыг явуулж эхэлсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж, цаашид анхаарч ажиллах талаар заавар, зөвлөгөө өгч, хяналт тавьж шаардлага тавин ажилласан.

Тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангуулан
ажиллах ажлын хүрээнд:

Авто тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг ханган ажиллахын тулд “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS4598:2011, автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт MNS4601:2011 стандартын дагуу ТҮ-1,ТҮ-2 үйлчилгээг заагдсан гүйлтийн дагуу жилд 2 удаа хийж хэвшсэн. Автомашины засварт зогсох хугацааг богиносгосон. Засвар үйлчилгээний графикайн дагуу 7 хоног бүрээр 2-3 автомашинд хөдөлгүүрийн тос солих, засвар үйлчилгээ хийх ажлыг тогтмолжуулан ажилласан. Үүнд:

- Хьюндай старекс маркын тээврийн хэрэгслүүдэд - 8ш амортизатор, урд хойд босоо тэнцүүлэгч, 2ш под крило, 2ш шарнер, гарны түлк, аккумулятор, 1ш шил арчигч зэрэг сэлбэгүүдийг шинээр сольсон.

- Хьюндай соната-7 маркын тээврийн хэрэгслүүдэд рулийн аппарат, 4ш амортизатор, аржектар, цапны шаарик 2ш босоо тэнцүүлэгч, 2ш өндгөн тулгуур, амортизаторын дээд тавган шаарик, 3ш урд буфер, сэвтэй тээврийн хэрэгслүүдийг кузов засварт оруулсан.

- Хьюндай азера маркын тээврийн хэрэгслүүдэд хойд пурш, хойд наклад, амортизаторын тавагны шаарик, кришканий тагны жийрэг 4ш амортизатор, урд буфер, баруун хойд урд хаалга зэрэг сэвтэй тээврийн хэрэгслүүдийг кузов засварт оруулсан.

- Гренжер маркын тээврийн хэрэгслүүдэд 4ш амортизатор бш катюшика, бш свечэ шинээр сольж, шинээр шил арчигч сольж, урсгал засварт оруулан бэлэн байдлыг хангасан.

- Оптима маркын тээврийн хэрэгслүүдэд үзлэг оношилгоо хийж ,коллектор цэвэрлэж хөдөлгүүрийн тос, зуны 20ш дугуй солих, тойрсон сэвтэй тээврийн хэрэгслүүдийг кузов засварт оруулсан.

- Ниссан тина маркын тээврийн хэрэгслүүдэд үзлэг оношилгоо хийж, кузов засварт оруулж сэв зураасыг янзлуулж, джнамны релей, 4ш свечей, аккумулятор, урд буфер, зөв талын хормой сэвтэй тээврийн хэрэгслүүдийг кузов засварт оруулсан.

- Аксент маркын тээврийн хэрэгслүүдийн урд буфер, сэвтэй тээврийн хэрэгслийг кузов засварт оруулсан.

- Волкесваген маркын тээврийн хэрэгслийн хойд буфер, сэвтэй тээврийн хэрэгслүүдийг кузов засварт оруулсан.

- Ланд 200 маркын тээврийн хэрэгслийг бүрэн кузов засварт тус тус оруулж ажилласан.

ХАБ инженер Г. Агваандондов Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй аюулгүй ажиллагааны зааварчилга нийт ажилтан, албан хаагчдад өгч, жолооч нарт өдөр бүр хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилга өгөн гарын үсэг зуруулж,

хэрэглэгчдэд үйлчилэхэд авто замын дүрэм зөрчих, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах чиглэлээр байгууллагын цахим хаягт заын хөдөлгөөний хууль, дүрэм, журмыг контент хэлбэрт оруулж, үйлчилгээний соёлыг сайжруулах зорилгоор жолооч нарын хувцаслалт, хувийн соёлд тавих шаардлагыг өндөржүүлсэн.

Байгууллага хооронд балансаас балансад шилжүүлэхээр Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХХК Волкесваген пасат маркын 06-23 УБӨ серийн дугаартай нэг тээврийн хэрэгсэл 70,000,000 төгрөг, Хьюндай бонго маркын 11-57 УНУ серийн дугаартай нэг тээврийн хэрэгсэл 72,826,667 төгрөгийн өртгөөр тус тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэн авч албажуулсан. Мөн 7,700,000 төгрөгийн өртөгөөр авто машин оношилгооны сканер 5D (компьютер) худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.


Тайлангийн хугацаанд инженерүүдийн болон диспетчерийн утсаар нийт 122 удаа автомашин захиалах дуудлага захиалагч байгууллагаас ирсэн ба дуудлага ирсэн даруйд цаг хугацаанд нь дуудлагыг хүлээн авч зохих заавар зөвлөмжийн дагуу үйлчилгээг үзүүлсэн.

Байгууллагын дүрмийн 4.3 Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасны дагуу санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтлөх, тайлан балансыг зохих хугацаанд нь гаргахад үйлчилгээнд явж буй тээврийн хэрэгслүүдийн анхан шатны бүртгэл болох замын хуудас, тооцооны хуудсыг тогтмол бүртгэлжүүлэн хөтөлсөн.

Авто баазын парк ашиглалтыг дээшлүүлэх зорилгоор 2021 оны байдлаар жилд давхардсан тоогоор 45 автомашинд засвар үйлчилгээ хийж байсан бол 2022 оны хагас жилийн байдлаар 45 автомашинд засвар үйлчилгээ хийгдсэн. Сэлбэгийн зардал, өмнөх оны сэлбэгийн зардлаас өссөн үзүүлэлттэй гарч байна. Энэ нь үнийн өсөлт, импортын сэлбэг ховордсонтой холбоотой. Тээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн оноор нь жагсаан насжилтын судалгааг гаргасан бөгөөд насжилт өндөртэй тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний зардлын судалгааг сүүлийн 3 жилээр харьцуулсан диаграмм үзүүлэлтийг хийсэн.


Байгууллагын тээврийн хэрэгслийн насжилтын судалгаа

Диаграмм-1




Насжилт өндөртэй тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний зардлын судалгааг сүүлийн 3 жилээр харьцуулсан график-2 үзүүлэлт

График-2




Парк ашиглалтын хувьд өнгөрсөн онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. 2021 оны Парк ашиглалтын коэффициентийн дундаж үзүүлэлт нь 85 % байсан бол 2022 оны Парк ашиглалтын коэффициентийн дундаж үзүүлэлт 88 % болж өссөн үзүүлэлттэй байна.


График-3



7 хоног тутам SMARTCAR.MN-ээр жолооч нарын торгуулийг шүүн төлбөрийн барагдуулалтад хяналт тавин ажилласнаар 2022 оны 1-р улиралд нийт 2,740,000 төгрөгийн торгуулийг механик инженер болон бригадын ахлагч нарт мэдээлэл өгч, хамтран ажилласнаар төлж барагдуулсан. Үүнийг схемээр үзүүлвэл:

Схем-4





Гурав.Төсөв, санхүүгийн талаар

Санхүү төлөвлөлтийн хэлтэс нь 2022 оны төсвийн жилийн хүрээнд 6 зорилтын хүрээнд 16 багц ажил төлөвлөн төлөвлөгөөний 40 орчим хувийн биелэлттэй өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Байгууллагын хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх, хангалт үйлчилгээг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулж, төсвийн үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавих, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн удирдлагыг бодит мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тайлант хугацаанд тайлагнан Сангийн яам, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн татварын

газар, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс, Нийгмийн Даатгалын хэлтэс, Нийслэл дэх Төрийн аудитын газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Статистикийн хэлтэст тус тус цаасан болон цахим хэлбэрээр нийт 9 тайланг бэлтгэн гаргаж баталгаажуулан ажилласан. 2021 оны санхүүгийн тайлан гаргахтай холбоотой зөрчил, алдааг тайлангийн хугацаанд залруулж үүссэн эрсдэлийн талаар тухай бүр удирдлагад танилцуулан холбогдох арга хэмжээг бүрэн авч залруулан ажилласан.

Батлагдсан орон тоо төсвийн дагуу цалингийн санхүүжилтийг авч сар бүрийн 10, 25-ны өдрүүдэд цалинг олгон Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хуулийн хугацаандаа багтаан гаргаж, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.

Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх ариутгал халдваргүйжүүлэлт хийх, ажилтан албан хаагчдын дархлааг дэмжих витаминжуулалтын аяны хүрээнд витаминжуулалтад 1.6 сая төгрөг, амны хаалт 0.9 сая төгрөг, түргэвчилсэн оношлуур 2.2 сая төгрөг, ариутгалын бодис 0.4 сая төгрөг, нийт 5.1 сая төгрөгийн зардал гаргасан.

2022 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Бүх нийтээр мод тарих өдөрт Хан-Уул дүүргийн айцын даваан дахь цэцэрлэгт хүрээлэнд мод тарих өдрийн арга хэмжээнд модны суулгац 0,9 төгрөг, бусад зардал 0,1 сая төгрөг тус тус зардлыг төсөвлөн шаардлагатай бээлий, шуудай авсан.

Байгууллагын эзэмшлийн 78 тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу 2022 оны үзлэг оношилгоонд хамруулахад шаардлагатай холбогдох төлбөр тооцоог, мөн нийт тээврийн хэрэгслийн 2022 оны албан татварын төлбөрийг 2022 оны 03 дугаар сард багтаан тээврийн хэрэгсэл тус бүрээр төлж, шилжилт хөдөлгөөн хийж буй 3 тээврийн хэрэгслүүдтэй холбоотой шаардлагатай албан журмын даатгалд хамруулан зохих журмын дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

Тээвэр зохицуулалтын хэлтсээс хэрэгжүүлж буй сар бүр хуваарийн дагуу засвар үйлчилгээнд орж байгаа автомашинуудад шаардлагатай сэлбэг хэрэгслийн худалдан авалтыг тухай бүр нь санхүүгийн нөхцөлд байдалтай уялдуулан төлөвлөж, худалдан авалтад анхааран дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Хэлтсийн ажилчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин холбогдох хууль стандартын дагуу бүртгэлийг хөтөлж, сар бүр техникч-нярав, эдийн засагч нягтлан бодогчийн хамт тухайн сарын ажлын төлөвлөгөөг боловсруулан Захиргаа хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн, газрын даргаар баталгаажуулан тайлан мэдээг хугацаанд гарган, ажиллаж байна.

Анхан шатны баримт болон кассын дэвтрийн хөтлөлтийг техникч-нярав өдөр тутамдаа хөтлөн, шатахууны баримт болон бусад орлого зарлагын анхан шатны баримтын дагуу санхүүгийн програмд тухай бүрт нь бүртгэлийг хөтлөн сар бүр тайлагнан эдийн засагч, нягтлан бодогч хяналт тавин ажиллаж байна. 2021 оны санхүүгийн баримт Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргэгдэн шалгагдаж байна.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ажиллагаатай холбоотой мэдээлэл

Тухайн жилд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гарган Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт албан бичгээр хүргүүлэн ажилласан.

Санхүүжилтийн эх үүсвэр: Өөрийн орлого

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төсөвт өртөг (сая.төг)	Тухайн онд санхүүжих (сая.төг)	Эрх шилжүүлэх эсэх (ТЭЗ-ийн нэр)	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам
1	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын үйлчилгээний тээврийн хэрэгслүүдэд шатахуун нийлүүлэх	299.9	118.1	-	Нээлттэй тендер шалгаруулалт

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын үйлчилгээний тээврийн хэргслүүдийн шатахуун нийлүүлэх тендерийг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр зарлаж тендер амжилтгүй болсон. Тендерийг дахин 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр зарлан 02 дугаар сарын 12-ны өдрөөр нээсэн. Тус тендерт манай байгууллагаас Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Н.Батцэцэг, санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Үүрцайх нар гишүүнээр оролцсон. Тендерт Петро стар ХХК, Магнай трейд ХХК, Шунхлай трейд ХХК-иуд тус тусын материал, үнийн санал ирүүлсэн ч төсөвт өртөг өндөр тул тендерт шалгараагүй. Төсөвт өртөг нь зарласан тендерийн үнийн санал, нөхцөлийн хангасан Содмонгол групп ХХК-тай 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

2022 оны Хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 360,7 сая төгрөг, төсвийн санхүүжилт 750.7 сая төгрөг, нийт 1,111.4 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус бүрдүүлээд байна.

**Нийслэлийн төр захиргааны авто бааз УТҮГ-ын
2022 оны орлогын харьцуулалт (сая.төг)**

Д/д	Орлого	2022 оны төлөвлөгөө	2022 оны хагас жилийн төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөгөөний биелэлтийн (хувь)
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	2420.3	388.1	15%
2	Үйл ажиллагааны бус бусад орлого	12960.0	0	0
3	Төсвийн санхүүжилт	1806.1	750.7	42%

2022 оны хагас жилийн байдлаар 1,374 сая төгрөгийн зардалтай, 2021 оны төлөвлөгөөнөөс 30% хувийн хэтрэлттэй ажилласан байна. Энэ нь автомашины засвар үйлчилгээ, тээврийн хэрэгслийн бүрэн даатгалт хийгдсэнтэй холбоотой мөн шинээр ашиглалтад орсон үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн үйл ажиллагааны зардал
(сая.төг)

Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2022 оны төлөвлөгөө	2022 оны Хүлээгдэж байгаа гүйцэтгэл	Гүйц (төл) хэмнэлт, хэтрэлт (+/-)	
				сая.төг	Хувь
Нийт зардлын дүн	3,018.5	137.0	1,648.1		
Цалин хөлс шагнал	1530.0	642.2	887.8	0	42%
Нийгмийн даатгалын шимтгэл	367.2	154.1	213.1	0	42%
ТХ-ийн татвар даатгал	44.6	38.3	14.0	0	31%
Ашиглалтын зардал	30.1	12.2	17.9	0	41%
Аж ахуйн материалын зардал	51.6	18.5	33.1	0	36%
Элэгдлийн зардал	363.5	151.4	212.1	0	42%
Шатахууны зардал	299.9	118.1	181.8	0	39%
Сэлбэг хэргэслийн зардал	195.3	153.5	41.8	0	78%
Засвар үйлчилгээний зардал	76.1	53.6	53.6	0	71%
Бусад зардал	60.2	32.1	28.1	0	53.3

Цалингийн зардалтай уялдан гарч буй нэг зардал бол нийгмийн хамгааллын буюу эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал юм.

Нийт 105 даатгуулагчийн 642.2 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод 151.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төсөвт төвлөрүүлсэн. Уг ногдуулсан шимтгэлийн 92.0 сая төгрөгийг даатгуулагчийн хөдөлмөрийн хөлснөөс суутган тооцсон бол 86 сая төгрөгийн шимтгэлийг ажил олгогчоос төлж тайлагнасан. Нийгмийн даатгалын тухай хуулийн 6.1-д заасан нийгмийн даатгалын сангаас олгодог Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг харьяа дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээр шалгуулан 20 ажилтанд 4.2 сая төгрөгийн тэтгэмжийг бодож олгосон байна.

Нэг удаагийн буцалтгүй тэтгэмж

Тайлант хугацаанд Өндөр насны тэтгэвэрт гарч буй болон эрүүл мэндийн шалтгааны улмаас хүндээр өвдсөн, ар гэрийн гачигдал гарсан ажилтан, албан хаагчдад нийт 32.1 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгосон.

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжийн 1 дэх заалтад “Нийслэлийн төсвийн байгууллага, өмчит үйлдвэрийн газрын 2015 оны Санхүүгийн жилийн анхны дансны гүйлгээ хийгдэх хугацаанаас эхлэн шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, ажиллахыг Нийслэл, дүүргийн бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай” гэж заасны дагуу хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, стандарт, журмын дагуу холбогдох мэдээллийг байршуулж ажиллаж байна.

Шилэн дансны тайланд сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, болон үйл ажиллагааны зардал тус бүрийг байршуулсан.

№	ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022
		1 сар	2 сар	3 сар	1-р улирал	4 сар	5 сар	6 сар	2-р улирал	7 сар	8 сар	9 сар	5-р улирал	10 сар	11 сар	12 сар	4-р улирал	Хэлс жил	Бүтэн жил
1	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэргэлт хэмжээний шилтгээн тайлбарын хант (Бүтэн жилээр,Хэлс жилээр,Улирал бүр,Сар бүр)	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
3	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	-	-
4	Өнөөч оны төсвийн зарлагын хэмжээ, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урьмчуулагда зарцуулсан тайлан (Бүтэн жилээр,Хэлс жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Хяндий, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр,Хэлс жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Шалтгааны зардалаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	-	-
7	Савоогуулийн тайлан (Бүтэн жилээр,Хэлс жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Савоогуулийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	✓

№	ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022	2022
		1 сар	2 сар	3 сар	1-р улирал	4 сар	5 сар	6 сар	2-р улирал	7 сар	8 сар	9 сар	5-р улирал	10 сар	11 сар	12 сар	4-р улирал	Хэлс жил	Бүтэн жил
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Харынгийн зардал, хөрөнгийн оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, коммешсан зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Сар бүр)	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	-	-
3	Харынгийн болон үрсэл зардалд тусгагдан арга хэмжээний төсвийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	-	-
4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	✓	✓	✓	-	-	-
5	Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	✓

№	ШИШЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛИЙН ТӨРӨЛ	2022			2022			2022			2022			2022			2022			2022	Бүтэн жил
		1 сар	2 сар	3 сар	1-р улирал	4 сар	5 сар	6 сар	2-р улирал	7 сар	8 сар	9 сар	3-р улирал	10 сар	11 сар	12 сар	4-р улирал	Класс	Бүтэн жил		
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)																				
2	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, км-нэцгэсэн зүйлийн хяналт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)	✓	✓	✓	-	✓	✓	○	-	○	○	○	-	○	○	○	-	-	-	-	○
3	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний төндөрийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)	✓	✓	✓	-	✓	✓	○	-	○	○	○	-	○	○	○	-	-	-	-	○
4	Төвийн санхүүгээр дэх үнэний дүн бүхий худалдан авсан барьц, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)	✓	✓	✓	-	✓	✓	○	-	○	○	○	-	○	○	○	-	-	-	-	○
5	Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	○

Байгууллагын албан хэрэгцээний үйлчилгээний 78 автомашины тээврийн хэрэгслийн техникийн оношилгоо, үйлчилгээнд хамруулахад 1.6 сая төгрөг, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, Тээврийн хэрэгслийн даатгал, 2022 оны албан татварт 38.3 сая төгрөгийн тус тус төлбөрийг төсөвлөн зарцуулсан.

ХАБЭА хариуцсан ажилтны мэргэжил олгох сургалтад механик инженер Г.Агваандондовыг хамруулан 500,0 төгрөгийн сургалтын төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн.

Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулан, эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллогыг хугацаанд нь хийн ажилласан. Ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгө, хангамжийн материалыг актлах саналыг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлж шийдвэрийн дагуу ажилласан.

Байгууллагын хөрөнгийн ашиглалт хадгалалтад хяналт тавьж, ажилтан тус бүрийн эзэмшиж буй хөрөнгийг өөрчлөлт орсон даруйд шинээр картжуулан эд хариуцагч нарт хүлээлгэн өгч тус бүрийг баталгаажуулан ажилласан.

Байгууллагын 2023 оны төсвийн төсөөлөл, 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон ажлын төлөвлөгөөг боловсруулан төсвийг хэмнэлттэй үр өгөөжтэй зарцуулах, төсвийн зардлыг бууруулах талаар арга хэмжээ авах, батлагдсан төсвийн хүрээнд зардлыг хэтрүүлэхгүй норм нормативыг баримтлан, цахилгаан дулаан ус холбооны зэрэг ашиглалтын зардлыг бууруулан, автомашинуудын засвар үйлчилгээг хугацаанд нь хийн өмчийн ашиглалтыг сайжруулж ажиллана.

Байгууллагын үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг үндэслэн норм, дуусах хугацааг тооцон шинээр хөрөнгө бэлдэх асуудлыг холбогдох байгууллагуудад гаргаж мэдээлсэн.

Дөрөв.Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Нийслэл дэх Төрийн аудитын ээлжит 2021 оны санхүүгийн иж бүрэн шалгалтад хамрагдан шаардлагатай баримт, тайлан мэдээг цаг тухайд нь гаргаж өгөн зөрчилгүй дүгнэлт авч ажилласан.

Нийслэл дэх Төрийн аудитын газраас ирүүлсэн хуваарийн дагуу 2021 оны санхүүгийн тайланд ээлжит шалгалтыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хийсэн. Тухайн шалгалттай холбоотой холбогдох баримт материалуудыг цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлэн шалгуулж, шаардлагатай тохиолдолд очиж нэн шаардлагатай баримт материалуудыг холбогдох хэлтсүүдээс авч хүргүүлэн амжилттай шалгуулан ажилласан.

Шилэн дансны тухай хуулийн хүрээнд сар бүрийн 7-ний өдөр холбогдох мэдээ, мэдээллийг тайлагнан ажиллаж байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ний өдөрт багтаан гаргаж газрын даргаар баталгаажуулан Нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтсийн холбогдох ажилтан хүргүүлэн, 2022 оны шатахуун нийлүүлэх тендерийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраар зохих журмын дагуу амжилттай зохион байгуулан төсөв, хөрөнгийн зарцуулалтын ил тод байдлыг шилэн дансны сайтад тогтмол байршуулж ажиллаж байна.